

# УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД

2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

## Хяналтын журмаар гомдол гаргах тухай

**Хариуцагч:** Монополын эсрэг газар

**Хаяг:** Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Засгийн газрын 9А байр

**Давж заалдах шатны шүүхийн магадлал:** Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 221/МА2025/0038 дугаартай магадлал

**Гомдлын шаардлага:** Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 128/ШШ2024/0911 дугаартай шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 221/МА2025/0038 дугаартай магадлалыг тус тус хүчингүй болгож, гомдол гаргагчийн гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгуулах

**Шаардлагын үндэслэл:** “Сод Монгол групп” ХХК-ийн гомдолтой, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар /хуучин нэрээр/-ын улсын байцаагчид холбогдох захиргааны хэргийг анхан болон давж заалдах шатны шүүхээс хянан шийдвэрлэхдээ хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байх тул хариуцагчийн зүгээс эс зөвшөөрч дараах үндэслэлээр гомдол гаргаж байна.

1. Давж заалдах шатны шүүхээс “Анхан шатны шүүх ...“Сод Монгол групп” ХХК-ийн ШТС-37 салбарт худалдаж байсан дизель тулшинд Иргэний нисэхийн ерөнхий газрын Оношилгоо, хэмжилзүйн лаборатори, Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхай, газрын тосны төв лабораториудын тайлан илтэд зөрүүтэй байхад Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч “Сод Монгол групп” ХХК-ийг санал стандартын шаардлага хангагүй шатахуун худалдсан зөрчил үйлдсэн гэж шийтгэл оногдуулсан нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, Өрсөлдөөний тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3.3, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.11 дүгээр зүйлийн 4.11.5, тус хуулийн 4.14 дүгээр зүйлийн 4.14.2, 6-д заасан хуулийн зохицуулалттай нийцэхгүй байна, энэ талаарх анхан шатны шүүхийн дүгнэлт үндэслэлтэй, зөв болжээ” гэж тус тус дүгнэсэн байна.

Хяналт шалгалтын явцад Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйл. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх 16.1.6-д “барааны чанар, аюулгүй байдалд итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгүүлж, дүгнэлт гаргуулах;” гэж заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын Оношилгоо, хэмжилзүйн лаборатори, Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхай, газрын тосны төв лабораториор шатахууны дээжийг шинжлүүлж мэргэжлийн байгууллагын холбогдох албан тушаалтан болох Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрчим хүчний /газрын тос, хий/ хяналтын Улсын ахлах байцаагч А.Бямбадорж 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 01-07-106/259, 01-07-106/260 дугаартай дүгнэлт гаргуулсан.

Уг дүгнэлтийн өөрт хамаарах хэсэгтэй гомдол гаргагч “Сод Монгол групп” ХХК болон шатахууны импорт, бөөн, жижиглэнгийн худалдаа эрхлэгч нэр бүхий 4 аж ахуй эрхлэгч шүүхэд 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр гомдол гаргаж /шүүхэд хэрэг нэгтгэгдэн хянагдсан/, тус шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 128/ШШ2024/0192 дугаар шүүхийн шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 221/МА2024/0384 дугаар магадлал, Монгол Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн шүүх хуралдааны 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 325 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрчим хүчний /газрын тос, хий/ хяналтын Улсын ахлах байцаагч А.Бямбадоржийн 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 01-07-106/259, 01-07-106/260 дугаартай дүгнэлтүүдийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүчингүй болгож эцэслэн шийдвэрлэсэн.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг илрүүлсэн, эсхүл гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шалгаж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:”, 2.1-д “гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх”, 2.2-т “гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах”, 2.3-т “хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх”; 2.4-д “зөрчлийн хэрэг нээх” гэж тус тус заасан.

Өөрөөр хэлбэл Зөрчлийн хэрэг нээж нэмэлт ажиллагаа явуулах шаардлагагүй буюу Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Дараах үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол эрх бүхий албан тушаалтан зөрчлийг газар дээр нь, эсхүл хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэнэ:”, 1.1.зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, зөрчил, учирсан хохирлыг нотлох талаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй бол; 1.2.зөрчил үйлдэгдсэн, учруулсан хохирол нь нотлох баримтаар тогтоогдож холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн бол; 1.3.зөрчил үйлдсэн болох нь стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжөөр нотлогдсон бол. гэж тус тус заасны дагуу хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, шийтгэл оногдуулсан нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагчийн шийтгэл оногдуулсан үйлдэл хуульд нийцээгүй гэх үндэслэлгүй юм.

2. Давж заалдах шатны шүүх “...шүүх зөвхөн улсын ахлах байцаагч А.Бямбадоржийн 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 01-07-106/259, 01-07-106/260 дугаартай дүгнэлтүүд хуульд нийцсэн эсэхийг хянасан байх ба уг дүгнэлтүүдийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн нь “Сод Монгол групп” ХХК-д шийтгэл оногдуулах үйлдлийг хууль нийцсэн гэж үзэх үндэслэл болохгүй” мөн “...шинжилгээний зөрүүг арилгаагүй, дахин шинжээч томилоогүй, маргаан таслахад авсан нэг дээжийг хадгалж, хамгаалах ажлыг зохион байгуулаагүй хариуцагчийн үйлдэл нь Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “хуульд үндэслэх”, 4.2.5-д “зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх” гэж заасан зарчимд нийцэхгүй байх...” гэж дүгнэсэн нь үйл баримт болон хэрэгт авагдсан нотлох баримтуудад үнэлэлт, дүгнэлт өгөөгүй байна.

Тодруулбал Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын албан бичгээр ирүүлсэн 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 01-07-106/259, 01-07-106/260 дугаартай

Улсын ахлах байцаагчийн дүгнэлт нь тухайн улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хийгдсэн эцэслэн гарсан дүгнэлт /шийдвэр/ бөгөөд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д заасны дагуу Төрийн хяналт шалгалт хийхэд төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага харилцан хүлээн зөвшөөрөх зарчмыг баримтлах бөгөөд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Улсын ахлах байцаагчийн дүгнэлтийг баримтлан тухайн зөрчилд шийтгэл оногдуулсан нь үндэслэлтэй юм.

2021 оны 03 дугаар сарын 19, 24-ний өдөр гомдол гаргагч “Сод Монгол групп” ХХК-ийн ШТС болон агуулахаас дээж авсан бөгөөд тус өдрөө маргаан таслахад зориулсан нэг дээжийг Гаалийн ерөнхий газрын төв лабораторид хадгалуулсан. Газрын тосны бүтээгдэхүүн. Дээж авах арга MNS 0218:2008 стандартын 7-д “Дээж савлах, ангилж хаяглах, хадгалах 7.7-д “Маргаан таслахад зориулсан, газрын тосны бүтээгдэхүүний дээжийг уг бүтээгдэхүүний илгээсэн өдрөөс хойш 45 хоног хадгална. Удаан хугацаагаар хадгалах буюу алс хол оршдог захиалагчид илгээсэн газрын тосны бүтээгдэхүүний маргаан таслах дээжийг 3 сар хадгална” гэж тус тус заасан.

Дээрх стандартын зохицуулалтаас үзэхэд “Сод Монгол групп” ХХК-ийн маргаан таслах дээж хадгалах хугацаа 2021 оны 05 дугаар сарын 03, 08-ны өдөр дууссан. Урт хугацаагаар нь буюу 3 сараар тооцож үзвэл 06 дугаар сарын 19, 24-ний өдөр дууссан. Өөрөөр хэлбэл маргаан таслах дээжний стандартад заасан хадгалах хугацаа дууссан тул шинжилгээ хийх боломжгүй гэж хариуцагчийн зүгээс үзэж байна.

Тиймээс “Сод Монгол групп” ХХК нь чанар, стандартын шаардлага хангагүй бүтээгдэхүүн болох дизель түлшийг зах зээлд борлуулж байсан нь лабораторийн сорилын дүн, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын ахлах байцаагчийн дүгнэлт зэргээр тогтоогдож байгаа бөгөөд анхан болон давж заалдах шатны шүүхээс хэрэгт авагдсан нотлох баримтуудад үнэлэлт, дүгнэлт өгөөгүй, хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоогоогүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Иймд Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 128/ШШ2024/0911 дугаартай шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 221/МА2025/0038 дугаартай магадлалыг тус тус хүчингүй болгож, гомдол гаргагчийн гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож өгнө үү.

#### ГОМДОЛ ГАРГАСАН:

МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗРЫН  
ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ,  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

У.ХАЛИУНАА  
Утас: 8800-0089